

“ҮЙЛДВЭРЛЭГЧ ХОВД ХӨТӨЛБӨР”**Нэг. Ерөнхий мэдээлэл**

“Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хууль, “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр, Ногоон хөгжлийн хөтөлбөр /2016-2026/, Ховд аймгийн хөгжлийн стратеги /2015-2025 он/, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд үндэслэн аймгийн үйлдвэрлэлийн салбарыг дэмжин хөгжүүлэх, орон нутгийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг болон жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор “Үйлдвэрлэгч Ховд” хөтөлбөрийг боловсруулсан болно.

Аймгийн “Ногоон хөгжлийн хөтөлбөр”-т Хүлэмжийн ялгарал багтай, дэвшилтэт технологид суурилсан, байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах “НОГООН ТӨСӨЛ”-үүдийг сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, бусад сангуудаас урт хугацаатай, хүү бага зээлээр дэмжих бодлого дэвшүүлсэн.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангана гэсэн зорилт туссан.

Аймгийн хэмжээнд нийт 2500 аж ахуйн нэгж иргэн үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Хүнсний үйлдвэрлэл -138, Эсгий, сүлжмэл, арьсан эдлэл - 42, Мод, модон эдлэл-58, Ахуйн үйлчилгээ -460, Барилгын материалын -53, Мал аж ахуй- 58, Бусад -56, барилга угсаралт-65 тээвэр 130, худалдаа, үйлчилгээ 890 ажиллаж байна.

Манай аймгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн байдлыг авч үзвэл барилгын дулаалгын хөөсөнцөр, сендвичин хавтан, вакум цонх, үйлдвэрийн аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангаж байна.

Мөн оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр албан байгууллагын оффисийн болон хөдөлмөр хамгааллын хувцасны хэрэглээг 20 хувь, явган замын хавтан 80 хувийг тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

Статистикийн газрын мэдээлэлд бизнес регистрийн санд 2016 онд 2276 аж ахуйн нэгж байсан бол 2017 оны байдлаар 2474 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн ДНБ үйлдвэрлэл 2016 онд 307.910.8 сая төгрөг байсан бол 2017 оны байдлаар 323.659.1 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 19.1%- ийг барилгын үйлдвэрлэл эзэлж байна. Аймгийн дүнгээр ажилгүй иргэдийн тоо 2016 онд 5368 байсан бол 2017 оны байдлаар 6056 болж өссөн байна. Үүнээс Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2017 оны байдлаар 1615 хүн байна. Бусад иргэд нь бүртгэлгүй ажилгүйчүүд эзэлж байна.

Ажилгүй иргэдийн тоо жил ирэх тутам өсч, сарын дундаж өрхийн орлого буурсан зэрэг дээрх үндсэн шалтгаанаас үүдэн иргэд үйлдвэрлэгчид хөрөнгө хуримтлалгүй, эргэлтийн хөрөнгөгүй, боловсон хүчний бодлого, бизнесийн төлөвлөлт хийх нөхцөлгүй байгаа нь эдийн засгийн тогтвортой хөгжил, үйлдвэржилтийн бодлогод сөргөөр нөлөөлж байна.

Энэ нөхцөл байдал нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжилд үйлдвэрлэлийн салбарын гүйцэтгэх үүрэг маш өндөр бөгөөд үйлдвэрийн түншлэл, кластер, инновацид суурилан өрсөлдөх чадварыг дээшлүүлэх арга туршлага дэлхийн улс орнуудад дэлгэрээд байна.

Аж үйлдвэрийг хөгжүүлснээр улс орны дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож, инфляцыг тогтворжуулах олон давуу талтай.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Өрхийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчид хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар түншлэлийг өргөжүүлэн, кластераар хөгжүүлж, тэдгээрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, дотоодын зах зээлийг хамгаалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн, эдийн засаг, нийгмийн өсөлтийг хангахад оршино.

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.1. Үйлдвэрлэл эрхлэгчдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар түншлэлийг өргөжүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх

2.2. Аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн дотоодын өрхийн үйлдвэрлэгчид, компаниудын үйл ажиллагааны тогтвортой, эдийн засгийн үр ашигтай байдлыг хангах, борлуулалтыг нэмэгдүүлэх

2.3. Аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг татах талаар гадаадын болон олон улсын байгууллагуудтай байнгын хамтын ажиллагааг бий болгох, уулзалт, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах

2.4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих зорилгоор холбогдох сургалт семинарыг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Политехник коллежтэй хамтран хэрэгжүүлнэ.

2.5 Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдолтой үйлдвэр эрхлэгчдийн жагсаалтыг гаргаж, түүхий эдийн нөөц, эрэлт, хэрэгцээг тулгуурлан хөгжүүлэх, олон улсын зах зээлд нийлүүлэх гарц, хамтын ажиллагааг дэмжих

2.6 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэрийг хүртээмжтэй, нээлттэй болгох, зээлийн батлан даалт гаргах үйлчилгээг өргөжүүлэх ажлыг зохион байгуулах, санхүүгийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

2.7 Зах зээлийг өргөтгөх, борлуулалтыг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжих:

2.8 Үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэлийн зориулалттай газрын асуудлыг бодлогоор дэмжин үйлдвэрлэлийн зориулалттай газар олголтыг нээлттэй, хүртээмжтэй олгох, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх

2.9. Үйлдвэрлэлийн зориулалтаар ажлын байр, тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслүүлэх, санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль эрх зүйн болон маркетинг, технологийн сургалт зохион байгуулах;

2.10. Шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аялал, сургалт зохион байгуулах;

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

3.1 Хөтөлбөрийг 2019–2022 онуудад хэрэгжүүлнэ.

3.2 Хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Үйлдвэрлэл эрхлэгчдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар түншлэлийг өргөжүүлэн, түүхий эд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх

3.2.1 Үйлдвэр эрхлэгчдийн бүртгэл судалгаа хийж, мэдээллийн нэгдсэн санг бий болгож, тэргүүлэх чиглэлийн салбар, бүтээгдэхүүнийг тодорхойлох;

3.2.2 Аймгийн төвд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлээр тусгай бүс бий болгон кластераар хөгжүүлж байгаль орчинд ээлтэй, экспортын баримжаатай, жижиг дунд үйлдвэрлэлийн Бизнес инкубатор төв байгуулах;

3.2.3 Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн, кластераар хөгжүүлэх ажлуудыг зохион байгуулах;

Зорилт 2. Аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн дотоодын компаниудын үйл ажиллагааны тогтвортой, эдийн засгийн үр ашигтай байдлыг хангах, борлуулалтыг нэмэгдүүлэх

3.2.4 Иргэд олон нийтэд үндэсний үйлдвэрлэлийг сурталчлах, контент, үзэсгэлэн худалдаа, форумыг төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах;

3.2.5 “Ховдод үйлдвэрлэв” төвийг түшиглэн бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг сурталчлах борлуулалтын төвүүдийг сумдад бий болгох;

Зорилт 3. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоотойгоор инновацид суурилан хөгжүүлэх

3.2.7 Төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн, дэвшилтэт техник технологи, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэлийг дэмжих төсөл хэрэгжүүлэх;

3.2.8 Их, дээд сургууль, төрийн бус болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалгаа хөгжүүлэлтийг сайжруулан шинэ санаа мэдлэгийг дэмжин ажиллах.

3.2.9 Ховд их сургууль, Политехник техник коллежоор дамжуулан удирдлагын болон мэргэжилтэй ажилтануудыг үйлдвэр үйлчилгээ эрхлэгч нарын захиалгаар бэлтгэх

Дөрөв. Хөтөлбөрийн бүтээгдэхүүн, үр нөлөө, шалгуур үзүүлэлт

Үр нөлөө: Аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалт бодитоор нэмэгдэх, судалгаа хөгжүүлэлтэд суурилсан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэл эрхлэгчид түншлэх тогтолцоо бий болох, өрсөлдөх чадвар сайжрах, ажлын байр нэмэгдэж улмаар аймгийн нийгэм, эдийн засаг чадавхижина.

Бүтээгдэхүүн:

4.1 Үйлдвэрлэл эрхлэгчдийг түүхий эд бэлтгэл нийлүүлэлтэд хамтран ажиллах талаар түншлэлийн тогтолцоог бий болгох чиглэлээр талуудын оролцоог хангах;

4.2 Сумдыг бүсчилсэн байдлаар үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлээр тусгай бүс байгуулах болон тэдгээрт түшиглэсэн бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг сурталчлах борлуулалтын төвүүдийг бий болгох;

4.3 Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн үйлдвэрлэлийн 2500 орчим аж ахуйн нэгжийн нэгдсэн мэдээллийн санг бий болгож, тэргүүлэх чиглэл

тодорхойлогдсоноор үйлдвэрлэл эрхлэгчдийн хоорондын уялдаа холбоо сайжирч түншлэл өргөжин, кластерын нэгдсэн системд оруулах;

4.4 Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;

4.5. Аймаг сумын “Брэнд бүтээгдэхүүн” бий болгох

4.6. Нэг суурин Нэг бахархалт бүтээгдэхүүн бий болгох аян өрнүүлэх

5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, үр дүн

5.1 Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээлэл цахим сүлжээнд бүртгэгдсэнээр нэгдсэн судалгаатай болно.

Ингэснээр Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд зорилтод бүлгүүдэд чиглэсэн ажил үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлэх, мөн хүссэн үйлдвэр эрхлэгчдийнхээ мэдээллийг үйл ажиллагааны чиглэл, овог нэр, регистрийн дугаар, утасны дугаараар хайлт хийн идэвхтэй, идэвхгүй үйл ажиллагаа эрхэлж байгааг нь онлайн-аар харах, захиалагч үйлдвэр эрхлэгчидтэй шууд харилцаа тогтоон нийлүүлэлт хийх боломжтой болно.

5.2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадваржуулах хууль эрх зүй, маркетинг, менежмент, өрсөлдөх чадварыг сайжруулахад шаардлагатай мэдлэг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулж, зөвлөх үйлчилгээ бий болсон байна.

5.3. Дэвшилтэд технологи, инновацид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах хамтын ажиллагаа, түншлэлийн тогтолцоо бий болгож тодорхой тооны иргэдийг ажлын байраар хангасан байна.

5.4. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэрийг хүртээмжтэй, нээлттэй болгох, шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин зээлийн батлан даалтын сангаар дамжуулан батлан даалт гаргаж, санхүүгийн боломжийг нэмэгдүүлсэн байна.

5.5. Тодорхой тооны үйлдвэр эрхлэгчид дэд бүтэц нь шийдвэрлэгдсэн үйлдвэрлэлийн зориулалттай газартай болсон байна.

5.6 Аймгийн цэцэрлэг, сургуулиудын ажилчдын дүрэмт хувцас болон бүжиг жүжгийн хувцас, ажлын хувцас зэргийг дотооддоо үйлдвэрлэх бүрэн боломжийг ашиглан захиалгаар нийлүүлэх, байгууллагуудтай гэрээ байгуулан захиалга авч, захиалагчийн хүсэлтийн дагуу бүтээгдэхүүн нийлүүлдэг болно.

5.7 Үйлдвэр эрхлэгчдийн борлуулалт сайжирч, аймгийн үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна.

5.8 Үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтын суваг нэмэгдэж, үзэсгэлэн худалдаанд оролцогчдын тоо 20 хувиар нэмэгдсэн байна.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

6.2. Улс, аймгийн төсвийн хөрөнгө

6.3. Орон нутгийн хөрөнгө оруулалт

6.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

6.5. Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

6.6. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

6.7. Сум хөгжүүлэх сан

6.8. Хөшөөт хөгжлийн сан

6.9 Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Аймгийн Засаг даргын Тамгын газар хяналт тавьж, Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоог хангана.

7.3. Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан зарцуулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд батлагдсан хуваарийн дагуу тайлагнана.

7.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий байгууллага хагас болон бүтэн жилээр хяналт-шинжилгээ хийнэ. Хяналт-шинжилгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.5. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үндэслэн үнэлгээг хийлгэх бөгөөд эцсийн үр дүнгийн судалгаа, шинжилгээг хөндлөнгийн байгууллагын оролцоотойгоор, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

7.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг холбогдох байгууллагууд цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

---o0o---